# 2.2. Дүнгийн нэгтгэл /Хичээлээр/

## 2.2. Дүнгийн нэгтгэл /хичээлээр/

Зөвхөн хичээлийн нэр дээр дарж орсоноор хичээлийн дүн бүртгэх боломжтой.

Тухайн нэг хичээлийг сонгож ангийн бүх суралцагчдын дүнг нэг цонхноос бүртгэж болно.



| Алхам | Үйл явц | Тайлбар |
|---|---|---|
| 1. | Хэрэглэгчийн эрх | Хичээлийн дүн бүртгэх эрхтэй ангийн багш болон сургалтын менежер системд нэвтрэн орно.<br><br>Анхаарах зүйлс: Дараах 2, 3, 4, 5-р алхамыг зөвхөн өөрийн хариуцаж буй ангийг сонгож дүн бүртгэж оруулна уу. |
| 2. | Хичээлийн хөтөлбөр сонгох | • Бага боловсролын өдрийн хөтөлбөр<br>• Суурь боловсролын өдрийн хөтөлбөр<br>• Бүрэн дунд боловсролын өдрийн хөтөлбөр |
| 3. | Анги сонгох | • Бага боловсрол /1,2,3,4,5-р анги/<br>• Суурь боловсрол /6,7,8,9 -р анги/<br>• Бүрэн дунд боловсрол /10,11,12-р анги/ |
| 4. | Бүлэг | Анги сонгоход үүсгэгдсэн бүлэг сонголтоор гарч ирнэ |
| 5. | Хөтөлбөрийн төрөл | Уг тушаал нь хөтөлбөр, бүлэг, анги сонгоход автоматаар харагдана. Жнь: 12-р анги А/311-2+А/275-3+А/61 дугаар бүхий тушаалуудыг дагаж мөрдөж байгаа.<br><br>Анхаарах зүйлс: Тухайн анги бүлэгт хамаарах зөв хөтөлбөрийн төрлийг сонгосноор суралцагчдийн жагсаалт гарна. |
| 6. | Хичээлийн нэр | Дүнг нь бүртгэх гэж буй хичээлийн нэрийг сонгож нэвтэрч орно. |

### 2.2.1 Хичээлийн дүн бүртгэх

Дүн оруулахаар сонгосон хичээлийн нэр дээр дарахад тухайн ангийн сурагчдын жагсаалт дараах байдалтай гарч ирнэ.



| Алхам | Үйл явц | Тайлбар |
|---|---|---|
| 1. | Анги | Хичээлийн дүнг нь бүртгэх ангийн сонголтууд байна. |
| 2. | Төрөл | • Бага боловсрол -Заавал судлах<br>• Суурь боловсрол – Заавал судлах, Сонгон судлах<br>• Бүрэн дунд боловсрол – Заавал судлах, Сонгон судлах<br><br>Төрлийн сонголтоос хамаарч хичээлийн жагсаалт гарна. Үүнээс хичээлийг сонгож дүн бүртгэнэ. |
| 3. | Хичээлийн нэр | Хичээлийн дүн бүртгэх хичээлийн нэрийг сонгох. |
| 4. | Суралцагч | Суралцагчийг сонгосон үед хичээлийн дүнг бүртгэх боломжтой учраас бүх суралцагчдийг бүртгэх болон зөвхөн тухайн хичээлийг судласан суралцагчдийг сонгож бүртгэнэ. |
| 5. | Дүн нэмэх | Уг **Дүн нэмэх** товчууд адилхан үйлдэл хийх тул Суралцагчдийг сонгосны дараа дүн нэмэх дарсанаар хичээлийн дүн оруулах цонх гарч ирнэ. |
| 6. | Дүн нэмэх | |

*Бүрэн дунд боловсролын түвшинд дүнг оруулахдаа **Сонгон судлах** хичээл төрлийг сонгосон үед тухайн түвшний сонгон үзэх шаардлагатай заавал төрлийн хичээлүүд харагдана.*

### 2.2.2 Хичээлийн дүн хадгалах/ Дүн илгээх/



| Алхам | Үйл явц | Тайлбар |
|---|---|---|
| 1. | Анги | Хичээлийн дүнг нь бүртгэх ангийн сонголт харагдана. |
| 2. | Төрөл | • Бага боловсрол -Заавал судлах<br>• Суурь боловсрол – Заавал судлах, Сонгон судлах<br>• Бүрэн дунд боловсрол – Заавал судлах, Сонгон судлах<br><br>Төрлийг сонгосоноор төрөл тус бүрээр хичээлийн жагсаалт харагдана. Үүнээс хичээлийг сонгож дүн бүртгэнэ. |
| 3. | Хичээл | Дүн оруулах хичээлийг сонгоно. |
| 4. | Дүн* | Бага боловсролын I-III ангийн суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтыг үгэн үнэлгээг Мэдээллийн системд оруулахдаа дараах системийн дугаарлалтын дагуу оруулна уу.<br><br>➢ Маш сайн – 5<br>➢ Хангалттай – 4<br>➢ Сайжирч байгаа – 3<br>➢ Анхаарах шаардлагатай - 2<br><br>Бусад IV-XII ангийн суралцагчдын дүнг гүйцэтгэлийн хувиар буюу 0-100 -аар дүнг бүртгэнэ. |
| 5. | Судалсан хэлбэр | Судалсан хэлбэрийг Хичээл сонголтоор болон хичээл дүйцүүлэх сонголтын аль нэгийг сонгож бүртгэнэ. |
| 6. | Хадгалах | Уг товч нь зөвхөн хянах үйлдэл бөгөөд хичээлүүдийн дүнгийн мэдээлэл үнэн зөв бөглөгдсөн бол заавал илгээх товч дарж бүртгэнэ. |
| 7. | Дүн илгээх | Уг илгээх үйлдлийг хийж байж сургалтын менежер хичээлийн дүнгүүдийг баталгаажуулах боломжтой болно. |

*Дүн* Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2013 оны 08 -р сарын 16 өдрийн №А/309 тушаалын нэгдүгээр хавсралт ёсоор Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын болон боловсролын чанарын үнэлгээний журам баримтласан.*